



“УВС ХҮНС” ХК

(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

**Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31**

Улаанбаатар 2025



“УВС ХҮНС” ХК

2024 оны 12 дугаар сарын 31–ний ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛ

АГУУЛГА	ХУУДАС
КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	1
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	3 – 4
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	9-29

КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“УВС ХҮНС” ХК

Улсын бүртгэлийн дугаар -1510001008

Регистрийн дугаар — 2001969

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны 6 дугаар сарын 17 -ны өдрийн А/152 дугаар тушаалаар “Архины үйлдвэрлэл” -ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

АЛБАН ХАЯГ:

Увс аймаг, Улаангом сум, 5 -р баг

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Лхагвасүрэн овогтой Мөнхнаран

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Лхагвасүрэн овогтой Нямгэрэл

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:

Ядмаа овогтой Мөнхжаргал

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ:

Бямбаа овогтой Дэлгэрмаа

ХАРИЛЦАГЧ БАНК:

Хаан Банк,
Голомт Банк,
Хас банк,
Төрийн банк,
Худалдаа Хөгжлийн Банк,

АУДИТОРУУД:

Пи Кэй Эф Монголиа Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

“УВС ХҮНС” ХК -ийн Гүйцэтгэх захирал Л.Нямгэрэл, Санхүүгийн албаны дарга Я.Мөнхжаргал, Ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрмаа нар энэхүү тайлангийн 5-35 дугаар хуудсанд тусгагдсан Компанийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Зөвлөл (СТОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

“УВС ХҮНС” ХК -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг нийтэд толилуулахыг зөвшөөрч батлав.



ЛХАГВАСҮРЭН ОВОГТОЙ НЯМГЭРЭЛ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЯДМАА ОВОГТОЙ МӨНХЖАРГАЛ
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2025 оны 4 дүгээр сарын 9 өдөр



НИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Даун Таун Бьюлдинг, #602 тоот,
Жамъяан гүний гудамж -18/1,
I дүгээр хороо. Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот-14240, Монгол улс

Утас: +976-75057979

Факс: +976-70186131

Имэйл: info@pkf.mn

Ref: 5/УКН/01/02052025/BP

“УВС ХҮНС” ХК

Улаангом сум, 5 -р баг
Увс аймаг, Монгол улс

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“УВС ХҮНС” ХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Дүгнэлт

Бид “УВС ХҮНС” ХК (цаашид “Компани” гэх) –ийн 2024 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогод аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2024 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага” хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (Үргэлжлэл)

"УВС ХҮНС" ХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудыг үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС - ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцооллууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

П.БАЯРМАА
Гүйцэтгэх захирал

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2025 оны 4 дүгээр сарын 9 өдөр

“УВС ХҮНС” ХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 БОЛОН 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 –НИЙ ӨДРӨӨ

		(төгрөгөөр)	
ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2023-12-31	2024-12-31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2	29,394,058.10	165,547,445.22
Дансны авлага	3	182,634,987.37	34,717,306.95
Татвар, НДШ -ийн авлага	4	22,518,404.96	5,524,056.15
Бусад авлага	5	707,006,248.68	792,988,395.86
Бараа материал	6	1,776,400,005.18	1,970,042,138.81
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	7	2,880,000.00	61,059,462.87
Эргэлтийн хөрөнгийн дүн		2,720,833,704.29	3,029,878,805.86
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	8	1,802,261,910.28	1,685,945,770.43
Биет бус хөрөнгө	9	219,690,019.60	194,689,447.15
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		2,021,951,929.88	1,880,635,217.58
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		4,742,785,634.17	4,910,514,023.44
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	10	8,320,362.58	8,968,855.61
Цалингийн өглөг	11	29,328,248.53	40,040,301.33
Татвар хураамжийн өр төлбөр	12	118,625,072.55	116,014,303.65
НДШ -ийн өр төлбөр	13	0.00	1,814,607.23
Богино хугацаат зээл	14	157,526,969.73	275,000,000.00
Хүүний өглөг	15	2,586,649.89	65,479.45
Богино хугацаат өр төлбөрийн дүн		316,387,303.28	441,903,547.27
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	16	900,498,868.70	0.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн		900,498,868.70	0.00
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		1,216,886,171.98	441,903,547.27
ЭЗДИЙН ӨМЧ			
Өмч :		0.00	0.00
- Төрийн			
- Хувийн	17	11,271,600.00	11,271,600.00
Нэмж төлөгдсөн капитал	18	3,465,126.06	3,465,126.06
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19	847,420,494.00	847,420,494.00
Эздийн өмчийн бусад хэсэг	20	179,179,658.00	179,179,658.00
Хуримтлагдсан ашиг	21	2,484,562,584.13	3,427,273,598.11
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		3,525,899,462.19	4,468,610,476.17
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		4,742,785,634.17	4,910,514,023.44

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)			
ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2023	2024
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	22	4,839,198,243.77	5,592,134,350.64
Борлуулалтын өртөг	22	2,878,379,301.70	3,206,906,508.99
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)		1,960,818,942.07	2,385,227,841.65
Борлуулалт маркетингийн зардал	23	307,578,405.49	305,762,205.06
Ерөнхий ба удирдлагын зардал	24	911,686,439.60	952,363,743.09
Санхүүгийн зардал	25	160,720,710.40	58,461,625.90
Бусад зардал	26	460,500.00	22,390,454.12
		1,380,446,055.49	1,338,978,028.17
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	27	201,414.45	993,125.40
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	28	0.00	2,591,222.44
		201,414.45	3,584,347.84
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)		580,574,301.03	1,049,834,161.32
Орлогын татварын зардал	29	58,083,338.66	107,123,147.34
ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)		522,490,962.37	942,711,013.98
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)			0.00
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)		522,490,962.37	942,711,013.98
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		0.00	0.00
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ДҮН		522,490,962.37	942,711,013.98
НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ (АЛДАГДАЛ)		4,635.46	8,363.60

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	14,736,726.06	0.00	847,420,494.00	0.00	1,962,071,621.76	2,824,228,841.82
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						0.00
Залруулсан үлдэгдэл	14,736,726.06	0.00	847,420,494.00	0.00	1,962,071,621.76	2,824,228,841.82
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					522,490,962.37	522,490,962.37
Бусад дэглэрэнгүй орлого						0.00
Өмчид гарсан өөрчлөлт	(3,465,126.06)	3,465,126.06		179,179,658.00		179,179,658.00
Зарласан ногдол ашиг						0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						0.00
2023 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	11,271,600.00	3,465,126.06	847,420,494.00	179,179,658.00	2,484,562,584.13	3,525,899,462.19
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	11,271,600.00	3,465,126.06	847,420,494.00	179,179,658.00	2,484,562,584.13	3,525,899,462.19
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					942,711,013.98	942,711,013.98
Бусад дэглэрэнгүй орлого						0.00
Өмчид гарсан өөрчлөлт						0.00
Зарласан ногдол ашиг						0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						0.00
2024 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	11,271,600.00	3,465,126.06	847,420,494.00	179,179,658.00	3,427,273,598.11	4,468,610,476.17

(төгрөгөөр)

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)		
ҮЗҮҮЛЭЛТ	2023	2024
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	5,340,403,461.66	6,124,500,381.94
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,340,403,461.66	6,124,500,381.94
Мөнгөн зарлагын дүн (-)	5,035,765,017.02	5,155,086,698.46
Ажиллагсдад төлсөн	618,657,751.26	724,632,704.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	181,600,000.00	186,200,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	2,533,870,050.45	2,586,675,337.32
Ашиглалтын зардалд төлсөн	112,890,862.58	132,578,947.74
Түлш, шатахуун, тээв.хөлс, сэл.хэр -д төлсөн	110,941,334.30	99,794,759.86
Хүүний төлбөрт төлсөн	158,134,060.51	60,982,796.34
Татварын байгууллагад төлсөн	907,052,237.53	919,510,566.72
Даатгалын төлбөрт төлсөн	2,097,415.00	2,222,310.00
Бусад мөнгөн зарлага	410,521,305.39	442,489,276.48
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	304,638,444.64	969,413,683.48
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	216,175,570.00	51,227,600.00
Үндсэн хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн	214,375,570.00	41,213,200.00
Биет бус хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн	1,800,000.00	10,014,400.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(216,175,570.00)	(51,227,600.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	500,000,000.00	0.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	500,000,000.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	893,574,196.31	783,025,838.43
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	893,574,196.31	783,025,838.43
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(393,574,196.31)	(783,025,838.43)
Валютын ханшийн зөрүү	201,414.45	993,142.07
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(304,909,907.22)	136,153,387.12
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	334,303,965.32	29,394,058.10
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,394,058.10	165,547,445.22

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

КОМПАНИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

УВС ХҮНС ХК нь 1942 оны 2 дугаар сард анх “Идэш тэжээлийн комбинат” нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, талх нарийн боов, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, газар тариалан, мал аж ахуй эрхэлж, туслах аж ахуйг хөгжүүлэн анхны гараагаа эхэлсэн байна. 30 гаруй жилийн дараа 1973 оноос жимс, жимсгэнэ боловсруулах, архи ундаа үйлдвэрлэх, давс олборлох болон угаалгын саван үйлдвэрлэх цехүүдийг шинээр ашиглалтанд оруулсан.

1984 онд үйлдвэрийн шинэ байрыг ашиглалтанд оруулж, орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулснаар хүнсний лаборато бүхий талх нарийн боов, сүү сүүн бүтээгдэхүүн, архи ундаа үйлдвэрлэх хүнсний томоохон үйлдвэр болон өргөжиж 1998 онд УВС ХҮНС ХК болсон байна.

2006 оноос Монгол орон даяар чацарганы тос, шүүс, архин бүтээгдэхүүнээ борлуулдаг сүлжээ, дотоод хяналтын итгэмжлэгдсэн лаборатори, чацаргана жимсний элит сортын талбайтай болсон. Улмаар 2007 онд “Увсын чацаргана” газар зүйн заалтыг Монгол улсад анх удаа бий болгон бүртгүүлж байсан ба 2022 онд Олон улсад хүлээн зөвшөөрөгдөн, Европын холбоонд газар зүйн заалтаа бүртгүүлсэн байна. Газар зүйн заалт гэж тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн нэрийг хэлдэг байна.

УВС ХҮНС ХК нь 2008; 2018 онуудад чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008 ба ISO 9001:2015 стандартыг, 2008; 2021 онуудад дотоод хяналтын лабораторийн MNS ISO/IES 17025:2007 ба MNS ISO/IES 17025:2018 стандартыг нэвтрүүлж, 2018 оноос хүнсний аюудгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000:2018 стандартыг нэвтрүүлэн, хөдөө аж ахуйн зохистой дадал Global GAP стандартыг хэрэгжүүлэн, жил бүр магадлангийн хяналт аудит хийлгэж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

1.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Нийцтэй байдлын мэдэгдэл

Санхүүгийн тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон түүнд нийцүүлэн Монгол улсын Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлангийн маягт", "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" -ын дагуу бэлтгэсэн байна.

Хэмжилтийн суурь

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгслүүдээс бусад зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

Тайлагнагч валют

Санхүүгийн тайлангуудыг Монгол улсад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн.

Тасралтгүй үйл ажиллагаа

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

Нягтлан бодох бүртгэлийн томоохон тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүнд нөлөөлөх үнэлгээ, таамаглал, тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Компани нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварын дарааллаар толилуулсан.

Зөвхөн хуулиар эрх олгосон тохиолдолд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбараар шаардсан эсвэл зөвшөөрч Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан тодруулснаас бусад тохиолдолд орлого, зарлагыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнаж болохгүй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

1) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кассад байгаа бэлэн мөнгө, банкинд байршуулсан бэлэн мөнгөнөөс (3 сар хүртэлх сарын хугацаатай хадгаламж) бүрдэнэ. Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, хөрвөх чадвар сайтай хөрөнгө болно.

2) Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

3) Бараа материал

Бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авалтын бүх өртөг зардал, хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдон гарсан бусад зардал орно. Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана.

Цэвэр боломжит үнийг тооцоход бизнесийн хэвийн нөхцөл дэх тооцоолсон борлуулах үнээс түүнийг иж бүрдэл болгоход тооцсон зардал болон борлуулалтын зардлыг хасаж тооцно.

Бараа материалын өртөг

Бараа материалын өртөг нь худалдан авалтын бүх өртөг зардал хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахдаа холбогдож гарсан бусад зардлаас бүрддэг.

Худалдан авалтын зардал

Бараа материалын худалдан авалтын өртөг нь худалдан авсан үнэ импортын татвар ба бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас тухайн аж ахуйн нэгж дараа нь нөхөж авахаас бусад), тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээний худалдан авалтад шууд хамаарах бусад зардлаас бүрддэг. Худалдан авалтын өртгийг тодорхойлохдоо худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлийг хасна.

Хувиргалтын зардал

Бараа материалын хувиргалтын зардал нь шууд хөдөлмөр гэх мэт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шууд хамааралтай зардлаас бүрддэг. Мөн материалыг бэлэн бүтээгдэхүүн болгон хувиргахад гардаг үйлдвэрлэлийн тогтмол ба хувьсах нэмэгдэл зардлын системчилсэн хуваарилалт нь хувиргалтын зардалд хамаардаг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл) (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

3) Бараа материал (үргэлжлэл)

Хувиргалтын зардал

Үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардал нь үйлдвэрлэлийн процесст ашиглагдаж байгаа үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж, хөрөнгийг ашиглах эрхийн хорогдуулга болон засварын зардал, үйлдвэрийн удирдлага ба захиргааны зардал гэх мэт үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс үл хамааран харьцангуй тогтвортой байдаг үйлдвэрлэлийн шууд бус зардлууд юм. Үйлдвэрлэлийн хувьсах нэмэгдэл зардал нь үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс шууд эсвэл ойролцоогоор шууд хамааран өөрчлөгддөг шууд бус хөдөлмөр, шууд бус материалын зардал гэх мэт үйлдвэрлэлийн шууд бус зардлууд юм.

Үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардлыг хувиргалтын зардалд шингээх хуваарилалт нь тухайн үйлдвэрлэлийн хэрэгслийн хэвийн хүчин чадалд үндэслэдэг. Хэвийн хүчин чадал гэдэг нь төлөвлөсөн засвар үйлчилгээний улмаас гарах хүчин чадлын алдагдлыг харгалзаж хассан бөгөөд олон тайлант үеүд буюу улирлуудын дундажаар тооцоход, хэвийн нөхцөл байдалд бий болгохоор хүлээгдэж буй үйлдвэрлэлийн тоо хэмжээ юм. Хэрэв үйлдвэрлэлийн бодит тоо хэмжээ нь хэвийн хүчин чадалтай ойролцоо байвал түүнийг тооцоололд ашиглаж болно. Үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хуваарилах тогтмол нэмэгдэл зардлын дүнг цөөн тоо хэмжээгээрх үйлдвэрлэл эсвэл сул зогсолтын улмаас нэмэгдүүлэхгүй. Ийм хуваарилагдаагүй үлдсэн нэмэгдэл зардлыг тухайн зардал гарсан тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрнө. Хэвийн бус их хэмжээний үйлдвэрлэл явуулсан тайлант үеүдэд тухайн бүтээгдэхүүнийг өртгөөс өндөр дүнгээр хэмжин тусгахгүйн тулд үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хуваарилах үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардлын дүнг бууруулна. Үйлдвэрлэлийн хувьсах нэмэгдэл зардлыг уг үйлдвэрлэлийн хэрэгслийн бодит ашиглалтад үндэслэн тухайн үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хуваариладаг.

Үйлдвэрлэлийн процессын явцад нэгээс олон тооны бүтээгдэхүүнийг нэгэн зэрэг үйлдвэрлэдэг байж болох юм. Тухайлбал хамсарсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг эсвэл үндсэн ба дайвар бүтээгдэхүүнтэй байх үед ийм тохиолдол үүсдэг. Бүтээгдэхүүн тус бүрийн хувиргалтын зардлыг тусад нь тодорхойлох боломжгүй байвал хувиргалтын зардлыг оновчтой бөгөөд тогтвортой суурьт үндэслэн тэдгээр бүтээгдэхүүнд хуваарилна. Тухайлбал: бүтээгдэхүүнийг тус тусад нь тодорхойлж чадах үйлдвэрлэлийн процессын тодорхой нэг үе шатанд эсвэл үйлдвэрлэл дууссан үед бүтээгдэхүүн тус бүрийн борлуулалтын харгалзах үнэд үндэслэн ийм хуваарилалтыг хийж болно. Өөрийн шинж төрлийн дагуу ихэнх дайвар бүтээгдэхүүн нь материаллаг бус байдаг. Ийм материаллаг бус байх үед дайвар бүтээгдэхүүнийг ихэвчлэн цэвэр боломжит үнэ цэнээр хэмжих ба үнэ цэнийг үндсэн бүтээгдэхүүний өртгөөс хасдаг. Ингэснээр үндсэн бүтээгдэхүүний дансны үнэ ба түүний өртгийн хооронд материаллаг хэмжээний зөрүү үүсэхгүй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл) (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

4) Гадаад валютаар гарсан ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн жил гүйлгээ гарсан өдрийн ханшид үндэслэн Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж нэгэн зэрэг бүртгэдэг.

Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн зүйлсийг тайлант хугацааны эцэст хаалтын ханшийг үндэслэн хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн буюу хүлээн авсан эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түүхэн өртгөөр илэрхийлэгдсэн, анх гадаад валютаар гарсан мөнгөн бус зүйлсийг түүнийг олж бэлтгэх үеийн түүхэн ханшийг ашиглан хөрвүүлж бүртгэдэг.

Гадаад валютын төгрөгтэй харьцах албан ханш:

	USD	RUB	CNY
2023 оны 12 дугаар сарын 31	3,410.69	37.67	480.01
2024 оны 12 дугаар сарын 31	3,420.46	32.04	468.60

5) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ.

Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Үндсэн хөрөнгийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй цэвэр үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэ(үлдэгдэл өртөг)-тэй харьцуулж тодорхойлдог ба олз, гарзыг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Машин тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл) (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

6) Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийг ашиглагдах хугацаанд нь шулуун шугамын аргаар элэгдүүлж, элэгдлийн зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

- | | |
|--------------------------------------|----------|
| • Барилга | 25 жил |
| • Машин тоног төхөөрөмж | 5-10 жил |
| • Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| • Тавилга, эд хогшил | 5-10 жил |
| • Компьютер түүний дагалдах хэрэгсэл | 2-10 жил |

7) Түрээсэлсэн хөрөнгө

Тухайлсан хөрөнгийг зөвшөөрсөн хугацаанд ашиглах эрхийг тодорхой төлбөртэйгөөр шилжүүлэх хэлцэл гэж компани нь тодорхойлж байгаа нөхцөлд ажил гүйлгээ буюу бүлэг ажил гүйлгээнээс бүрдэх хэлцлийг түрээс гэж үздэг. Тухайн тохиолдолд хэлцлийн шинж байдлыг үнэлсний үр дүнд хийдэг бөгөөд энэ хэлцэл нь түрээсийг хууль зүйн хэлбэртэй эсэхээс үл хамаарна.

Компанийн түрээсэлж буй хөрөнгийн ангилал

- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлэх нөхцөлтэй бол санхүүгийн түрээсээр,
- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг бүрэн шилжүүлэх нөхцөлгүй түрээсийг үйл ажиллагааны түрээсээр ангилна.

Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг бүрэн шилжүүлэх үед үүсэх санхүүгийн түрээсийг түрээсэлсэн хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр эсвэл түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээс эхэлсэн үед нь хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн төлбөрүүд нь санхүүгийн зардал ба түрээсийн өглөгийн бууралтад хуваагдах бөгөөд өглөгийн эцсийн үлдэгдэлд тогтмол хүү тооцдог. Санхүүгийн зардлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түрээсэлсэн хөрөнгийг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны турш элэгдүүлдэг. Түрээсийн хугацааны эцэст эзэмшил нь компанид шилжих эсэх нь тодорхойгүй үед хөрөнгийг ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаагаар элэгдүүлдэг.

Үйл ажиллагааны түрээс

Компани нь үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмших хөрөнгө ашиглаж буй тохиолдолд түрээсийн дагуу хийгдсэн төлбөрүүдийг түрээсийн хугацааны тайлант үеүдэд тэнцүү хэмжээгээр орлого зардлаар тайлагнадаг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл) (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

8) Сангууд

Компанид (а) өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хууль, ёс зүйн) байгаа (б) энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Компани нь байгуулсан сангийн зарим хэсгийг эсвэл бүгдийг нөхөн төлбөрт зарцуулахаар хүлээж байгаа үед нөхөн төлбөр хийх нь бодитой болсон үед л зөвхөн төлбөрийг тусдаа хөрөнгө болгон хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг сантай холбоотой зардлыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

9) Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөх өдөр

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анх хүлээн зөвшөөрөхдөө ажил гүйлгээ хийсэн өдөр хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэх ба тухайн бодит үнэ цэнэ эсвэл хүлээн авсан Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдээс бусад санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хэмжихдээ гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ. Компанийн санхүүгийн хөрөнгөд зээл ба авлага орно.

Зээл ба авлага

Зээл ба авлага нь идэвхитэй зах зээлд бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр бүхий үүсмэл санхүүгийн хэрэглүүр бус санхүүгийн хөрөнгө юм.

Анх хүлээн зөвшөөрсний дараа санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ:

1. Хорогдуулсан өртгөөр
2. Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр үнээр
3. Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тус тус хэмжинэ.

Хэмжилтийн сонголт нь санхүүгийн хөрөнгийг удирдан зохицуулах тухайн аж ахуйн нэгжийн бизнесийн загвар, гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанараас хамаарна.

Санхүүгийн хөрөнгө нь мөнгө, худалдааны ба бусад авлага, борлуулахад бэлэн байгаа үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслээс бүрдэнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл) (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

10) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- Компани тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл
- Компани хөрөнгийн дийлэнхи эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Компанийн санхүүгийн өр төлбөрүүдэд зээллэг, үүсмэл санхүүгийн өр төлбөр, хүүгийн өглөг дансны болон бусад өр төлбөр орно.

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг.

Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл) (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

11) Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд зохих журмын дагуу хөрөнгө борлуулснаас орж ирэх эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийг бодит үнэ байна.

Бодит үнэ цэнийн хэмжилтийг дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээнд үндэслэн хийдэг. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн давуу зах зээлд

Үндсэн зах зээл болон хамгийн давуу зах зээл нь Компанийн хувьд оролцож болохуйц зах зээл байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадах эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгөх нөхцөлд тооцно.

Компани нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай орцууд хангалттай үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн багаар ашиглана.

